ДАРХАН-УУЛ АЙМАГ

# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 14 өдөр Дугаар 42 Дархан

Хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “ж”, 19 дугаар зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Дархан Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨХХК-ийн хуулийн этгээдийн хэлбэрийг өөрчилж Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар болгон өөрчилсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 76 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дархан-Уул аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г. ЭРДЭНЭБАТ

001000142

D:/documentshural/togtool/